

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын
төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн

АУДИТЫН КОД: ГСА-2024/18-06-ШТА-ГА

Чойр 2024 он

Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын
газрын дарга, тэргүүлэх аудитор:
Б.Сарантуяа, Утас: 70543179
Цахим хаяг: Sarantuyab@audit.gov.mn

Аудитын менежер: Г.Наранбаяр,
Утас: 70543179
Цахим хаяг: Naranbayarg@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Дарханбат, Утас: 70543179
Цахим хаяг: darkhanbatb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт
мэдээллийг дараах хаягаар авна уу.
Цахим хуудас: www.audit.mn

Тайланг бэлтгэсэн:

Говьсүмбэр аймаг дахь
Төрийн аудитын газар

Дарга, тэргүүлэх аудитор
Б.Сарантуяа

Аудитын менежер
Г.Наранбаяр

Ахлах аудитор
Б.Дарханбат

Аудитор
Г.Ариунцэцэг

Аудитын тайлан,
дүгнэлттэй холбоотой
асуудлаар нэмж
тодруулах, асууж лавлах
зүйл байвал 70543179
дугаарын утсаар
харилцана уу.

ХАЯГ:

Сүмбэр сум 3-р баг,
Нутгийн удирдлагын
ордон, 213 тоот

2024 оны 06 дугаар сар

А.Төсөл, арга хэмжээний ажлын даалгавар, техникийн тодорхойлолтыг холбогдох норм, дүрмийн дагуу боловсруулсан боловч төсөвт өртөг, санхүүжих дүнг бодитой тооцож төлөвлөөгүй байна. 7

А.1 2023 онд шинээр хэрэгжихээр батлагдсан 7 төсөл, арга хэмжээний ажлын даалгавар, техникийн тодорхойлолт, зураг төсвийг хууль тогтоомж, норм, дүрэм журмын дагуу боловсруулсан байна. 7

А.2 Аймгийн ИТХ-ын тогтоолд өмнөх оноос шилжих хөрөнгө оруулалтын ажлын төсөвт өртгийг дутуу баталсан. Халуун усны барилгын төсөвт өртгийн тооцооллыг үндэслэлтэй тооцож, эрх бүхий байгууллагаар батлуулаагүй байна. 8

А.3. Төсөл, арга хэмжээний санхүүжилтийг гүйцэтгэлд үндэслэн олгосон байна. 9

Б. Аймгийн ИТХ-аар батлагдсан төсөл, арга хэмжээг төлөвлөсөн хугацаанд нь хэрэгжүүлж ажиллахгүй байгаа нь хөрөнгө оруулалтын ажлын үр ашгийг бууруулж байна. 9

Б.1. Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгасан 7 төсөл, арга хэмжээнд хугацаанд нь гүйцэтгүүлж хүлээн аваагүй, 1 ажлыг техникийн шаардлага, ажлын тоо хэмжээний дагуу хэрэгжүүлээгүй байна. 9

Б.2. Захиалагч 2 төсөл, арга хэмжээнд зураг төсөв зохиогчоор хяналт тавиулаагүй, улсын комисс ажлын тоо хэмжээ дутуу, үүрэг даалгаврыг бүрэн хэрэгжүүлээгүй 1 ажлыг хүлээн авсан байна. 10

Б.3. Ашиглалтад хүлээн авсан 89.9 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг ашиглагч байгууллага данс бүртгэлд тусгаагүй байна 12

В.Тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн боловч хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт 50 хувьтай зорилтот түвшиндээ хүрээгүй байна. 12

В.1. Ашиглалтад хүлээн авсан 25.7 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг зориулалтын дагуу ашиглаагүй, хөрөнгө оруулалтын үр өгөөжийг бууруулж байна.12

В.2. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ нь тэргүүлэх ач холбогдол, хэрэгцээ шаардлагыг хангасан ч төлөвлөсөн үр дүндээ хүрээгүй байна.13

Дүгнэлт

Зөвлөмж

Дээд шатны байгууллагад хүргүүлэх санал

Шалгагдагч байгууллагын санал тайлбар

Тайлан баталгаажуулах тушаал

Тайлангийн хавсралтууд

ТОВЧИЛСОН ҮГС

АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт
ГХБХБГ	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ХАА	Худалдан авах ажиллагаа
АИТХ	Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурал
ТАХ	Төсөл арга хэмжээ
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ХБТХОХ	Хөгжлийн бодлого төлөвлөлт , хөрөнгө оруулалтын хэлтэс

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Аудит хийх
үндэслэл,
бүрэн эрх:

Төрийн аудитын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 11.5 дахь заалтыг үндэслэн мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2023 оны 09 дүгээр тогтоол, Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын гүйцэтгэлийн төлөвлөгөө, Үндэсний аудитын газрын нэгдсэн төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэлээ.

Аудитын
зорилт:

Орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдсэн. Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэсэн. Үүнд:

- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний холбогдох тооцоолол, баримт бичгийг үндэслэлтэй боловсруулж, санхүүжүүлсэн эсэх;
- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хугацаанд нь гүйцэтгүүлж хүлээн авсан эсэх;
- Хэрэгжсэн төсөл, арга хэмжээ төлөвлөсөн үр дүнд хүрсэн эсэх;

Аудитад
ашигласан
шалгуур
үзүүлэлт:

Дараах хууль эрх зүйн актын холбогдох заалтуудыг аудитын шалгуур үзүүлэлт болгон ашиглав.

- Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль;
- Төсвийн тухай хууль;
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- Барилгын тухай хууль;
- Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тогтоол
- Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр
- Барилга байгууламж үнэ бүрдэл, төсөв зохиох норм ба дүрэм, стандарт;
- Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”;
- Сангийн сайдын 2018 оны 281 дүгээр тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”;
- Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар батлагдсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлж, эрэмбэлэх үйл ажиллагааны журам, болон холбогдох аргачлалууд”;
- Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”;
- Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”;
- Барилга, байгууламжийн батлагдсан зураг, төсөв, ТЭЗҮ, магадлалын ерөнхий дүгнэлт, байгуулсан гэрээ болон бусад холбогдох эрх зүйн актууд.

Аудитын
хамарсан
хүрээ:

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг 2023 онд хэрэгжүүлсэн ТЕЗ болон тэдгээрийн харьяа байгууллагууд аймгийн ЗДТГ, ГХБХБГ, ОНӨГ болон холбогдох бусад гүйцэтгэгч аж ахуйн нэгжийг хамруулан төсөл, арга хэмжээний төлөвлөлт, ТЭЗҮ, зураг төсөл, магадлалын ерөнхий дүгнэлт, ХАА-ны төлөвлөгөө, тайлан, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ түүний хэрэгжилт, баталгаажуулсан ажлын

Аудитын
арга зүй:

гүйцэтгэл, олгосон санхүүжилт, эрх бүхий байгууллагуудаас хяналт хийсэн ажлын тайлан болон төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнгийн хүрээнд аудит хийлээ.

Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 100, 300, 400, 3000-3100, Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020 “Гүйцэтгэлийн аудитын зарчим”, MNS 6817-6:2020 “Нийцлийн аудитын зарчим”, MNS 6817-7:2020 “Гүйцэтгэлийн аудитын стандарт”, MNS 6817-8:2020 “Нийцлийн аудитын стандарт” Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт, түүвэрлэлт хийх, судалгаа явуулах арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүгнэлт, зөвлөмжийг боловсрууллаа.

Аудит хийх
багийн
бүрэлдэхүүн,
хугацаа:

Аудитыг дарга, Тэргүүлэх аудитор Б.Сарантуяа хянан удирдаж, үе шатны хяналтыг аудитын менежер Г.Наранбаяр хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Дарханбат, аудитор Г.Ариунцэцэг нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэлээ.

Хүндрэл
бэрхшээл:

Аудитын гүйцэтгэлийн үе шатыг 2024 оны 03 дугаар сарын 15-ны өдрөөс эхлүүлж, тайланг Тэргүүлэх аудиторын тушаалаар баталгаажуулан шалгагдагч байгууллага болон холбогдох эрх бүхий албан тушаалтанд 2024 оны 06 дугаар сарын 10-ны өдөр хүргүүлээ.

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Аймгийн ИТХ-ын 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн хуралдааны 11 дүгээр тогтоолоор Орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд шинээр эхлэх хөрөнгө оруулалтын 3 төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр 653.9 сая, шилжих төсөл арга хэмжээнд 709.7 сая, нийт 1,363.7 сая төгрөгийн төсөв баталсан. 2023 оны 18 дугаар хуралдааны 3 дугаар тогтоолоор төсөвт тодотгол хийж, орон нутгийн 2023 оны төсвийн хөрөнгө оруулалтыг 1,531.9 сая төгрөгөөр баталсан байна.

АИТХ-ын 2023 оны 18-р хуралдааны 3-р тогтоолоор батлагдсан
Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөө

№	Хөрөнгө оруулалтын ТАХ- ний ангилал	2022 оноос шилжсэн		2023 оноос шинээр хэрэгжсэн	
		Тоо хэмжээ	төсөвт өртөг	Тоо хэмжээ	төсөвт өртөг
1	Барилга байгууламж	2	360.5	2	307
2	Их засвар	1	19.4	1	364.9
3	Тоног төхөөрөмж	1	107.3	3	152
4	ТЭЗҮ	3	20.9	1	200
	Нийт	7	508.1	7	1023.9

Тайлант хугацаанд шинээр эхлэх 7 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчтэй 1,012.3 сая төгрөгийн гэрээ байгуулж 731.8 сая, өмнөх оноос шилжсэн 7 төсөл, арга хэмжээнээс 5 төсөл, арга хэмжээнд 331.5 сая, нийт 1,063.2 сая төгрөгийн санхүүжилтийг гүйцэтгэгчид олгосон байна.

ТЕЗ-ийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд Орон нутгийн төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх 1,023.8 сая төгрөгийн 7 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулсан бөгөөд үүнээс 582.8 сая төгрөгийн 2 төсөл, арга хэмжээг НТШ, 241.0 сая төгрөгийн 4 төсөл, арга хэмжээг харьцуулалтын аргаар, 200.0

сая төгрөгийн 1 төслийг зөвлөх үйлчилгээний хосолмол үнэлгээний аргаар тус тус худалдан авах ажиллагааг зохион байгуулж, 7 гүйцэтгэгчтэй 1,012.3 сая төгрөгийн гэрээ байгуулах эрхийг олгож, 11.5 сая төгрөгийн хэмнэлт үүссэн байна.

Дүрслэл товъёог

№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл 1	Ажлын тоо хэмжээнээс дутуу хийгдсэн 2,3,6-р байрны цахилгааны самбар, монтаж /100 самбар/	9
Дүрслэл 2	1,4,5,7,8,9,10,11,12,15 байранд хийсэн цахилгааны самбар	10
Дүрслэл 3	Зориулалтын дагуу ашиглах боломжгүй байгаа Талын илч ОНӨААТҮГ-т хүлээлгэн өгсөн цахилгааны нөөц үүсгүүр	12

Хүснэгтийн товъёог

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Ажлын даалгавар, тоо хэмжээ, зураг төсөвтэй төсөл, арга хэмжээний жагсаалт	7
Хүснэгт 2	Төсөвт өртгийг дутуу баталсан ТАХ-ний жагсаалт	8
Хүснэгт 3	Батлагдсан төсөл, арга хэмжээний гүйцэтгэл	9
Хүснэгт 4	2023 онд эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээний жагсаалт	9-10
Хүснэгт 5	Хүлээн авсан төсөл, арга хэмжээний жагсаалт	10-11
Хүснэгт 6	Төлөвлөсөн үр дүндээ хүрээгүй төсөл, арга хэмжээний жагсаалт	13

Хавсралтын товъёог

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хавсралт 1	ТАХ-ний санхүүжилт олгосон жагсаалт	19-20
Хавсралт 2	Дараа онд шилжсэн ТАХ-ний жагсаалт	21-22
Хавсралт 3	Тайлант хугацаанд хүлээн авсан ТАХ-ний жагсаалт	22-23
Хавсралт 4	Гэрээний хугацаа дууссан, сунгалт хийгээгүй, алданги тооцох ТАХ-ний жагсаалт	23-24

БҮЛЭГ А

Төсөл, арга хэмжээний ажлын даалгавар, техникийн тодорхойлолтыг холбогдох норм, дүрмийн дагуу боловсруулсан боловч төсөвт өртөг, санхүүжих дүнг бодитой тооцож төлөвлөөгүй байна.

А.1 2023 онд шинээр хэрэгжихээр батлагдсан 7 төсөл, арга хэмжээний ажлын даалгавар, техникийн тодорхойлолт, зураг төсвийг хууль тогтоомж, норм, дүрэм журмын дагуу боловсруулсан байна.

Тайлант хугацаанд шинээр хэрэгжүүлэх 7 арга хэмжээ төлөвлөснөөс 7 ажилд техникийн тодорхойлолт, зураг төсөв, ажлын даалгаврыг бүрэн боловсруулсан байна.

Хүснэгт №1

(сая төгрөгөөр)

№	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг	Ажлын даалгавар боловсруулсан байгууллага	Техникийн тодорхойлолт боловсруулсан байгууллага	Зураг төсвийг боловсруулж магадлалаар баталгаажуулсан эсэх
1	Шивээговь сумын шинэ суурьшлын бүсэд худаг гаргуулах, ухаалаг систем суурилуулах ажил	89.1	АЗДТГ, ГХБХБГ	АЗДТГ, ГХБХБГ	Тийм
2	Чойр хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг тодотгож, шинэчлэл хийх ажил	200.0	АЗДТГ, ГХБХБГ	АЗДТГ, ГХБХБГ	Хүлээн авахаас өмнө магадлалаар баталгаажуулна.
3	Сүмбэр сумын 1-р баг Худалдаачны гудамжны тохижилтын ажил	217.9	АЗДТГ, ГХБХБГ	АЗДТГ, ГХБХБГ	Тийм
4	УС-ДУ ОНӨААТҮГ-азарт аваарын нөөц генератор худалдан авах ажил	50.0	АЗДТГ, УС-ДУ ОНӨААТҮГ	АЗДТГ, УС-ДУ ОНӨААТҮГ	Шаардлагагүй
5	Стандарт хэмжилзүйн хэлтэст шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах ажил	50.0	АЗДТГ, Стандарт хэмжилзүйн хэлтэс	АЗДТГ, Стандарт хэмжилзүйн хэлтэс	Шаардлагагүй
6	Баянтал, Шивээговь сумдад нөөц генератор худалдан авах ажил	52.0	АЗДТГ, Илчлэг шивээ, Талын илч ОНӨААТҮГ	АЗДТГ, Илчлэг шивээ, Талын илч ОНӨААТҮГ	Шаардлагагүй
7	Орон нутгийн өмчит байгууллагуудын их засварын ажил	364.9	АЗДТГ, ГХБХБГ	АЗДТГ, ГХБХБГ	Тийм
Нийт		1,023.8			

(Эх сурвалж: Төрийн цахим худалдан авах ажиллагааны системд нийтэлсэн тендерийн баримт бичиг, ХАА-ын тайлан)

Хүснэгтээс харахад: Тоног төхөөрөмжийн техникийн тодорхойлолтыг ашиглагч байгууллагатай зөвшилцөн боловсруулсан байна.

Өмнөх оноос шилжсэн 7 төсөл арга хэмжээнээс 2 нь төсөв батлагдсаны дараа зураг төсөв нь магадлалаар баталгаажсан байна. Үүнд:

- Сүмбэр сумын Найрамдал хотхонд шинээр баригдаж байгаа барилгуудын цахилгаан хангамжийн ажил
- Халуун усны барилгын ажил /Сүмбэр сум, 2 дугаар баг/

Дээрх зөрчилд өмнөх аудитаар зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгсөн бөгөөд тайлант онд алдаа зөрчлийг давтан гаргаагүй байна.

А.2 Аймгийн ИТХ-ын тогтоолд өмнөх оноос шилжих хөрөнгө оруулалтын ажлын төсөвт өртгийг дутуу баталсан байна. Халуун усны барилгын төсөвт өртгийн тооцооллыг үндэслэлтэй тооцож, эрх бүхий байгууллагаар батлуулаагүй байна.

Төсөвт өртгийг дутуу баталсан ТАХ-ний жагсаалт

Хүснэгт №2

(сая төгрөгөөр)

№	ТАХ-ний нэр	Төсөл, арга хэмжээний ангилал	Нийт төсөвт өртөг	2023 онд батлагдсан төсөвт өртөг	2023 онд санхүүжих дүн	Зөрүү
1	Сүмбэр сумын Найрамдал хотхонд шинээр баригдаж байгаа барилгуудын цахилгаан хангамжийн ажил	Барилга байгууламж	241.0	137.6	137.6	103.4
2	Сүмбэр сумын Найрамдал хотхонд шинээр баригдаж байгаа барилгуудын цахилгаан хангамжийн ажил	Их засвар	94.4	-	-	94.0
3	Халуун усны барилгын ажил /Сүмбэр сум, 2 дугаар баг/	Барилга байгууламж	357.0	223.0	223.0	134.0
4	Шинэ суурьшлын бүс үүсгэх зураг төсөв боловсруулах ажил	ТЭЗҮ	22.5	6.7	6.7	15.8
5	1-р багт дахин төлөвлөлт хэрэгжүүлэх байршилд ерөнхий төлөвлөгөөний зураг төсөв боловсруулах	ТЭЗҮ	18.4	9.2	9.2	9.2
6	Нийтийн эзэмшлийн байрнуудын цахилгааны шит монтаж засварын ажил	Их засвар	89.9	19.4	19.4	70.5
Нийт			823.2	395.8	395.8	427.0

(Эх сурвалж: Аудитын судалгаа-2024)

Хүснэгтээс харахад: Өмнөх оноос шилжсэн 6 төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг 2023 оны санхүүжих дүнтэй ижил баталснаас шалтгаалан төсөвт өртгийг 427.0 сая төгрөгөөр дутуу баталжээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2.6¹, 68 дугаар зүйлийн 68.1²-т заасныг зөрчсөн тул зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

Мөн 2023 оноос 2024 онд шилжих 2 төсөл арга хэмжээг дараа онд шилжих ажлын төсөвт тусгаж батлуулаагүй, 1 ажлын төсөвт өртгийн өөрчлөлтийг эрх бүхий байгууллагаар хянуулж батлуулаагүй байна. Үүнд:

1. “Сүмбэр сум 2 дугаар багийн халуун усны барилгын ажил”-д 2023 оны байдлаар 312.7 сая төгрөгийн санхүүжилт олгож 37.4 сая төгрөгийг барьцаа дансанд байршуулсан. Мөн төсөвт өртөг, санхүүжих дүнг бодитой тогтоож баталгаажуулахгүйгээр орон нутгийн 2024 оны төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд уг ажлын төсөвт өртгийг 150.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж баталсан байна.

2. “Сүмбэр сумын 1-р баг Худалдаачны гудамжны тохижилтын ажил”-д 2023 оны байдлаар 135.5 сая төгрөгийн санхүүжилт олгож, 79.0 сая төгрөгийг барьцаа дансанд байршуулсан байна.

Төсөвт өртгийг бодитоор тооцож, эрх бүхий байгууллагаар баталгаажуулаагүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5³-д заасан төсвийн ил тод нээлттэй байх зарчим, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-т заасан өрсөлдөх тэгш боломжоор хангагдахгүй байх эрсдэлийг үүсгэж байгаа тул зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

¹ 33.2.6.хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар /нэр, байршил, хүчин чадал, төслийн код, хэрэгжүүлэх хугацаа, төсөвт өртөг, анхны төсөвт өртөг, санхүүжүүлэх эх үүсвэр, тухайн төсвийн жилийн санхүүжилтийн дүн/;

² 68.1.Орон нутгийн төсөвт энэ хуулийн 33.2.1-33.2.7-д заасныг тусгаж, батална.

³ 6.5.1.төсөв хэлэлцэх, батлах үйл ажиллагааг нийтэд нээлттэй байлгаж, төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэл, тайлагналын талаар тогтоосон хугацаанд нийтэд ойлгомжтой, хүртээмжтэй байдлаар мэдээлэх;

А.3. Төсөл, арга хэмжээний санхүүжилтийг гүйцэтгэлд үндэслэн олгосон байна.

Шинээр эхлэх 7 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчтэй 1,012.3 сая төгрөгийн гэрээ байгуулж 731.8 сая, өмнөх оноос шилжсэн 7 төсөл, арга хэмжээнээс 5 төсөл, арга хэмжээнд 331.5 сая нийт 1,063.2 сая төгрөгийн санхүүжилтийг гүйцэтгэгчид олгосон байна.

Мөн худалдан авах ажиллагаанаас үүссэн гэрээний хэмнэлт 11.5 сая, магадалшгүй ажлын зардлын хэмнэлт 1.5 сая төгрөгийг орон нутгийн ерөнхий орлогын дансанд төвлөрүүлж, ТАХ-ний барьцаа 19.1 сая, тайлант онд санхүүжилт бүрэн авах боломжгүй болсон 4 төсөл, арга хэмжээний 277.8 сая төгрөгийг барьцаа дансанд төвлөрүүлжээ. /Дэлгэрэнгүйг хавсралт №1-ээс үзнэ үү./

БҮЛЭГ Б Аймгийн ИТХ-аар батлагдсан төсөл, арга хэмжээг төлөвлөсөн хугацаанд нь хэрэгжүүлж ажиллахгүй байгаа нь хөрөнгө оруулалтын ажлын үр ашгийг бууруулж байна.

Б.1. Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгасан 7 төсөл, арга хэмжээнд хугацаанд нь гүйцэтгүүлж хүлээн аваагүй, 1 ажлыг техникийн шаардлага, ажлын тоо хэмжээний дагуу хэрэгжүүлээгүй байна.

2023 онд Орон нутгийн хөрөнгө оруулалтаар нийт 1,952.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 14 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр батлуулсан бөгөөд төлөвлөсөн төсөл арга хэмжээний гүйцэтгэл 50%-тай байна.

Хүснэгт №3		Батлагдсан төсөл, арга хэмжээний гүйцэтгэл						(сая төгрөгөөр)
№	ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ АНГИЛАЛ	БАТЛАГДСАН		ГҮЙЦЭТГЭЛ		ЗӨРҮҮ		НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ ЭЗЛЭХ ХУВЬ
		Тоо	Төсөвт өртөг	Тоо	Төсөвт өртөг	Тоо	Төсөвт өртөг	
1	Барилга байгууламж	3	897.9	1	89.1	2	808.8	10%
2	Их засвар	3	549.1	2	454.7	1	94.4	83%
3	Тоног төхөөрөмж	4	259.4	4	259.4	0	0	100%
4	ТЭЗҮ	4	245.9			4	245.9	0%
НИЙТ		14	1,952.3	7	803.2	7	1,149.1	50%

(Эх сурвалж: Аудитын судалгаа-2024)

Хүснэгтээс харахад: 2023 онд барилга байгууламж ангилалд батлагдсан 897.9 сая төгрөгийн 4 төслөөс 89.1 сая төгрөгийн 1 төсөл хэрэгжиж хүлээн авсан бол, ТЭЗҮ ангилалд батлагдсан зураг төсвийн ажлаас тайлант хугацаанд бүрэн хэрэгжсэн зураг төсөв байхгүй байгаа нь гүйцэтгэл үр дүнд сөрөг нөлөө үзүүлж байна.

Анх төлөвлөсөн хугацаандаа хэрэгжээгүй, гэрээний хугацааг баримтлаагүй дараа онд шилжсэн 1,149.1 сая төгрөгийн 7 төсөл, арга хэмжээ байна.

Хүснэгт №4		(сая төгрөгөөр)	
№	ТАХ-ний нэр	Гэрээний дүн	Гэрээний хугацаа
1	1-р багт дахин төлөвлөлт хэрэгжүүлэх байршилд ерөнхий төлөвлөгөөний зураг төсөв боловсруулах	18.4	2021.02.22-2021.12.27
2	Сүмбэр сумын Найрамдал хотхонд шинээр баригдаж байгаа барилгуудын цахилгаан хангамжийн ажил	335.2	2022.12.01-2023.12.31
3	Дулааны станцын дулаан дамжуулах төвүүдийн мэдээлэл, холбооны шугамын ажлын зураг, төсөв боловсруулах ажил	5.0	2022.12.23-2023.05.10
4	Халуун усны барилгын ажил /Сүмбэр сум, 2 дугаар баг/	350.1	2022.07.18-2023.12.01
5	Шинэ суурьшлын бүс үүсгэх зураг төсөв боловсруулах ажил	22.5	2022.05.04-2023.04.20

6	Сүмбэр сумын 1-р баг Худалдаачны гудамжны тохижилтын ажил	214.5	2023.08.09-2023.12.01
7	Чойр хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг тодотгож, шинэчлэл хийх ажил	198.0	2023.08.04-2024.02.29
Нийт		1,143.7	

(Эх сурвалж: Аудитын судалгаа-2024, дэлгэрэнгүйг хавсралт №2-аас харна уу)

2021 онд 1, 2022 онд 4 төсөл, арга хэмжээний гэрээг байгуулсан нь нийт төсөвт өртгийн 37 хувийг эзэлж байгаа боловч 2024 оны эхний улирлын байдлаар ашиглалтад ороогүй, хэрэгжиж дуусаагүй байна.

Орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд “**Нийтийн эзэмшлийн байрнуудын цахилгааны щит монтаж засварын ажил**” батлагдсан. Нийт 330 цахилгааны самбарыг солихоор төлөвлөсөн боловч 230-ийг сольсон бөгөөд захиалагч, гүйцэтгэгч талууд зөвшилцөн ажлыг хүлээн авахаар шийдвэрлэжээ.

Энэ нь ковид-19 цар тахлын улмаас бараа материалын үнийн өсөлт үүссэн гэх боловч үнийн өсөлтийг баталгаажуулаагүй, төлөвлөсөн ажлын тоо хэмжээнээс 39.1 сая төгрөгийн өртөг бүхий 100 самбарыг дутуу хүлээн авсан байна. Мөн суурилуулсан самбар нь MNS5834:2008 Монгол Улсын стандартын 3.1, 6.2.12, 6.2.13-т заасан шаардлагуудыг хангахгүй байгаа нь иргэдийн эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл үзүүлж болохуйц (цахилгаан хүчдэлд цохиулах) байна.



Зураг №1: Ажлын тоо хэмжээнээс дутуу хийгдсэн 2,3,6-р байрны цахилгааны самбар, монтаж /100 самбар/

Орон нутгийн төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд “**Шивээговь сумын шинэ суурьшлын бүсэд худаг гаргуулах, ухаалаг систем суурилуулах ажил**”-ын төсөвт өртгийг 89.1 сая төгрөгөөр баталсан боловч худалдан авах ажиллагаа амжилтгүй болсон. 2023 оны төлөвлөгөөнд захиалагч тоо хэмжээг бууруулан худгийн барилга, тоног төхөөрөмжийг хасан зөвхөн шугамын ажлыг 87.0 сая төгрөгөөр гүйцэтгүүлсэн байна.

Хөрөнгө оруулалтын ажлыг гэрээний хугацаанд гүйцэтгүүлээгүйгээс он дамжин хэрэгжиж байгаа нь хөрөнгө оруулалтын ажлын төсөвт өртөг нэмэгдэх, анх төлөвлөсөн үр дүндээ хүрэхгүй байх, төсөл, арга хэмжээний үр ашиг буурах эрсдэлтэй байгааг анхаарч үзэх шаардлагатай тул аймгийн ТЕЗ-д Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3-т заасан чиг үүргээ хэрэгжүүлэх, гэрээний хугацааг баримтлаагүй гүйцэтгэгч компанид алданги тооцох зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

Б.2. Захиалагч 2 төсөл, арга хэмжээнд зураг төсөв зохиогчоор хяналт тавиулаагүй, улсын комисс ажлын тоо хэмжээ дутуу, үүрэг даалгаврыг бүрэн хэрэгжүүлээгүй 1 ажлыг хүлээн авсан байна.

Тайлант хугацаанд хэрэгжсэн 14 төсөл, арга хэмжээнээс 803.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 732.7 сая төгрөгийн санхүүжих дүн бүхий 7 төсөл, арга хэмжээ буюу нийт төлөвлөсөн ажлын 50 хувийг улсын комисс ажиллаж хүлээн авсан байна.

Улсын комисс хүлээн авсан төсөл арга хэмжээний жагсаалт

Хүснэгт №5

(сая төгрөгөөр)

№	Төсөл, арга хэмжээний ангилал	Хүлээн авсан ТАХ		Явцын хяналт хэрэгжүүлсэн эсэх	
		Тоо	Төсөвт өртөг	Зохиогч	Захиалагч
1	Барилга байгууламж	1	89.1	Хэрэгжүүлээгүй	Хэрэгжүүлсэн
2	Их засвар	2	454.7	Хэрэгжүүлээгүй	Хэрэгжүүлсэн
3	Тоног төхөөрөмж	4	259.4	Шаардлагагүй	Хэрэгжүүлсэн
4	ТЭЗҮ	0	0	Шаардлагагүй	Шаардлагагүй
Нийт		7	803.2		

(Эх сурвалж: ГХБХБГ-ын захиалагчийн хяналт тайлан, хөрөнгө оруулалтын ажлын анхан шатны баримт, дэлгэрэнгүйг хавсралт №2-оос үзнэ үү.)

“Нийтийн эзэмшлийн байрнуудын цахилгааны щит монтаж засварын ажил”-ын улсын комиссын үүрэг даалгаварт өгсөн “Цахилгаан щитны тоолуурын заалтын цонх хаалтгүй, бүх хаалгыг түгжээтэй болгох” үүрэг даалгавар бүрэн биеллээгүй байхад 2023 оны 09 дүгээр сарын 12-ны өдөр №ГСАОНӨГ/2021112008 гэрээт ажлыг хүлээн авах ажлын хэсэг акт үйлдэж хүлээн авсан нь Засгийн газрын 2021 оны 212-р тогтоолоор батлагдсан “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”-ийн 7 дугаар зүйлийн 7.6⁴, 8 дугаар зүйлийн 8.1⁵, 8.2.2⁶-т заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд ажлын тоо хэмжээнээс дутуу 39.1 сая төгрөгийн өртөг бүхий 100 самбарыг бүрэн угсруулах, улсын комиссын өгсөн үүрэг даалгаврыг биелэлтийг хангуулж, зөрчлийг арилгах албан шаардлагыг захиалагч буюу аймгийн ЗДТГ-т өгөхөөр шийдвэрлэв.



Зураг №2: 1,4,5,7,8,9,10,11,12,15 байранд хийсэн цахилгааны самбар онгорхой, зай завсрыг битүүмжлээгүй улсын комиссын үүрэг даалгаврын биелэлт хангагдаагүй байхад хүлээн авсан байна.

Барилгын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.32⁷, 37 дугаар зүйлийн 37.1.5⁸-т заасны дагуу барилгын ажлыг зураг төсөл, норм норматив, техникийн шаардлагын дагуу баригдаж буй эсэхийг зураг төсөв зохиогчийн хяналтын байгууллага хяналт хэрэгжүүлэх хуулийн зохицуулалттай байна.

Тайлант хугацаанд Барилга, байгууламж ангилалд батлагдаж хүлээн авсан “Шивээговь сумын шинэ суурьшлын бүсэд худаг гаргуулах, ухаалаг систем суурилуулах ажил”, Их засвар ангилалд батлагдсан “Нийтийн эзэмшлийн байрнуудын цахилгааны шит монтаж засварын

⁴ 7.6. Комисс ажилласны дараа комиссын гишүүд өгсөн санал, үүрэг даалгаврын биелэлтийг шалгаж, биелэлт хангагдсан тохиолдолд энэ дүрмийн 4 дүгээр хавсралтад заасан үүрэг даалгаврын биелэлтийн хуудсанд гарын үсэг зурж баталгаажуулна.

⁵ Захиалагч, гүйцэтгэгч талууд илэрсэн зөрчил дутагдлыг ажлын 14 өдөрт багтаан арилгаж, комиссын хуралдаанаас даалгасан үүрэг даалгаврын биелэлтийг хангаж, шаардлагатай баримт бичгийг бүрдүүлнэ.

⁶ 8.2.2. энэ дүрмийн 5.1, 6.1-д заасан шаардлага хангаагүй, 8.1-д заасан хугацаанд үүрэг даалгаврын биелэлт хангагдаагүй тохиолдолд татгалзсан дүгнэлт

⁷ 4.1.32. "зураг төсөл зохиогчийн хяналт" гэж барилгын ажил, зураг төсөл, норм, нормативын баримт бичгийн дагуу гүйцэтгэж байгаа эсэхийг зохиогчоос хянаж байгаа үйл ажиллагааг;

⁸ 37.1.5. барилгын ажлын үе шат бүрд зохиогчийн хяналт хийлгэж, хөндлөнгийн лабораторийн шинжилгээгээр материал, хийц, бүтээц, эдлэхүүний чанар, аюулгүй байдлын техникийн үзүүлэлтүүдийг тодорхойлуулж, холбогдох зардлыг хариуцах;

ажил”-д зураг төсөв зохиогчийн хяналт хэрэгжүүлээгүй бөгөөд хяналтын зардал болох 1.5 сая төгрөгийг орон нутгийн ерөнхий орлогын дансанд төвлөрүүлсэн байна.

Мөн дараа онд шилжсэн “Сүмбэр сумын 1-р баг Худалдаачны гудамжны тохижилтын ажил”-д зураг төсөв зохиогчийн хяналтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь барилга байгууламж зураг төсөл, норм норматив, техникийн шаардлагын дагуу гүйцэтгэж буй эсэхийг баталгаажуулах боломжгүй болж чанаргүй барилга байгууламж баригдах эрсдэлийг үүсгэж байна. Дээрх асуудлаар өмнөх аудитаар албан шаардлага өгсөн бөгөөд хэрэгжилт хангалтгүй байгааг захиалагч анхаарч үзэх шаардлагатай байна.

Б.3. Ашиглалтад хүлээн авсан 89.9 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг ашиглагч байгууллага данс бүртгэлд тусгаагүй байна.

Тайлант хугацаанд ашиглалтад хүлээн авсан 803.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 732.7 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 7 төсөл, арга хэмжээнээс 89.9 сая төгрөгийн 1 тоног төхөөрөмжийг ашиглагч байгууллага данс бүртгэлд тусгаагүйгээс эзэнгүйдсэн байна. Үүнд:

1. Өмнөх оноос шилжин хэрэгжсэн “Нийтийн эзэмшлийн байрнуудын цахилгааны шит монтаж засвар”-ын 89.9 сая төгрөгийн ажлыг бүртгэлд тусгах АИТХ-ын шийдвэр гараагүй тул одоог хүртэл холбогдох байгууллагын данс бүртгэлд тусгаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 14 дүгээр зүйлийн 14.4.2⁹, Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24¹⁰, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2¹¹, Засгийн газрын 2021 оны 160-р тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.1.31¹²-т заасныг тус тус зөрчсөн тул албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

БҮЛЭГ В

Тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн боловч хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт 50 хувьтай зорилтот түвшиндээ хүрээгүй байна.

В.1. Ашиглалтад хүлээн авсан 25.7 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг зориулалтын дагуу ашиглаагүй, хөрөнгө оруулалтын үр өгөөжийг бууруулж байна.

Баянтал сумын Талын илч, Шивээговь сумын Илчлэг Шивээ ОНӨААТҮГ-т орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 51.5 сая төгрөгийн хөрөнгөөр “Цахилгааны нөөц үүсгүүр”-ийг нийлүүлсэн боловч Талын илч ОНӨААТҮГ-т нийлүүлсэн 25.7 сая төгрөгийн нөөц үүсгүүрийн цэнэг хураагчид гарсан алдаанаас шалтгаалж зориулалтын дагуу ашиглаагүй байна.

Иймд гэрээнд заасан хугацаанд тоног төхөөрөмжийг хэвийн байдалд оруулж илэрсэн зөрчлийг арилгах албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.



Зураг №3 Зориулалтын дагуу ашиглах боломжгүй байгаа Талын илч ОНӨААТҮГ-т хүлээлгэн өгсөн цахилгааны нөөц үүсгүүр

⁹ 14.4.2.бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага;

¹⁰ 4.1.24."төсвийн хөрөнгө оруулалт" гэж улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг;

¹¹ 2.Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө нь төрийн болон орон нутгийн өмч байна. Төсөвт авсан зээл, хандив, дэмжлэг, тусламжаар бий болсон хөрөнгө үүнд нэгэн адил хамаарна.

¹² 4.1.31.Эцсийн санхүүжилтийг авахад тухайн барилга байгууламж, тоног төхөөрөмжийг ашиглагч байгууллага нь бүртгэлд тусгасныг нотлох баримт үйлдэж баримт бичгийн иж бүрдэлд хавсаргана.

В.2. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ нь тэргүүлэх ач холбогдол, хэрэгцээ шаардлагыг хангасан ч төлөвлөсөн үр дүндээ хүрээгүй байна.

Орон нутгийн 2023 оны хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн 14 ТАХ-нээс 7 төсөл, арга хэмжээ төлөвлөсөн үр дүндээ хүрээгүй байна.

Төлөвлөсөн үр дүндээ хүрээгүй төсөл, арга хэмжээний жагсаалт

Хүснэгт №6				(сая төгрөгөөр)	
№	Төлөвлөсөн үр дүнд хүрээгүй ТАХ-ний нэр	Төсөвт өртөг	2023 оны ажлын гүйцэтгэл	Шалтгаан	Мөнгөн дүн
1	Сүмбэр сумын Найрамдал хотхонд шинээр баригдаж байгаа барилгуудын цахилгаан хангамжийн ажил	335.3	0%	Сүндэр хотхоны цахилгаан хангамжийг холбох болсонтой холбогдуулан техникийн тодорхойлолтод заасан ажлын тоо хэмжээнд өөрчлөлт орох болсон гэх шалтгаанаар ажил хойшилсон.	0
2	Халуун усны барилгын ажил /Сүмбэр сум, 2 дугаар баг/	350.1	85%	Батлагдсан зураг төсвөөс ажлын тоо хэмжээг багасгасан төсөвт өртөгт зөрүү үүссэн, барилгын материалын үнийн өсөлтийг тооцоолоогүй зэргээс шалтгаалан 2024 оны төсөвт 150.0 сая төгрөгийг нэмж тодотгосон бөгөөд дараа онд шилжсэн.	223.0 (37.7 сая төгрөгийн санхүүжилтийг авах боломжгүй болсон тул барьцаа дансанд шилжүүлсэн)
3	Шинэ суурьшлын бүс үүсгэх зураг төсөв боловсруулах ажил	22.5	0%	Газрын харилцаа, барилга барилга хот байгуулалтын газар, Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлаар ерөнхий төлөвлөгөөг танилцуулах ажил тодорхойгүй хугацаагаар хойшлогдсон гэх шалтгаанаар дараа онд шилжсэн.	0
4	1-р багт дахин төлөвлөлт хэрэгжүүлэх байршилд ерөнхий төлөвлөгөөний зураг төсөв боловсруулах	18.4	0%	Ерөнхий төлөвлөгөөний зураг төсөл батлагдахгүй удсан шалтгааны улмаас ажил зогсонги байдалтай дараа онд шилжсэн.	0
5	Чойр хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг тодотгож, шинэчлэл хийх ажил	200.0	90%	Гүйцэтгэгч байгууллагын үйл ажиллагаа болон зураг төсөв батлах үйл явцтай холбоотойгоор дараа онд шилжсэн.	158.4 (39.6 сая төгрөг дараа онд шилжсэн.)
6	Сүмбэр сумын 1-р баг Худалдаачны гудамжны тохижилтын ажил	214.5	65%	Тендер шалгаруулалтыг 2 удаа зарласан бөгөөд гүйцэтгэгч шалгараагүй шалтгаанаар шууд гэрээг 2023 оны 08 сарын 09-ний өдөр гэрээ байгуулсан тул төлөвлөсөн хугацаанд ашиглалтад орох боломжгүй болсон байна.	135.5 (79.0 сая төгрөг дараа онд шилжсэн.)
7	Дулааны станцын дулаан дамжуулах төвүүдийн мэдээлэл, холбооны шугамын ажлын зураг, төсөв боловсруулах ажил	5.0	90%	Гүйцэтгэгч байгууллагын үйл ажиллагаа болон зураг төсөв батлах үйл явцтай холбоотойгоор дараа онд шилжсэн.	5.0
Нийт		1,149.1	47.1%		521.9

(Эх сурвалж: ХБТХОХ-ээс авсан судалгаа, асуулга, ажлын баримт, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний анхан шатны баримт)

Хүснэгтээс харахад: Тайлант хугацаанд Найрамдал хотхоны цахилгааны хангамжийн ажил, Шинэ суурьшлын бүс үүсгэх зураг төсөв, 1-р багт дахин төлөвлөлт хэрэгжүүлэх байршилд ерөнхий төлөвлөгөөний зураг төсөв боловсруулах ажлууд ажлын тоо хэмжээнд өөрчлөлт орох, ерөнхий төлөвлөгөө батлагдаагүй, АИТХ-ын төлөөлөгчдөд танилцуулах хурал хойшилсон зэрэг шалтгаанаар огт гүйцэтгэл гаргаагүй, дараа онд шилжсэн байна.

Орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгасан 14 төсөл, арга хэмжээнээс 7 нь хугацаандаа хэрэгжиж, 7 нь он дамжсан бөгөөд төлөвлөгөөний хэрэгжилт 50 хувьтай байна. Цаашид хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгасан төсөл, арга хэмжээг төлөвлөсөн хугацаанд хэрэгжүүлж төлөвлөсөн зорилт, үр дүнг хангах шаардлагатай байна.

Аудитаар нийт 154.7 сая төгрөгийн зөрчил илэрснээс төсвийн ил тод нээлттэй байдал, худалдан авах ажиллагааны тэгш өрсөлдөх зарчмыг баримтлах, хөрөнгө оруулалтын ажлын үр ашгийн сайжруулах, гэрээ хугацааг баримтлаагүй төсөл, арга хэмжээнд алданги тооцох 2 зөвлөмж, 154.7 сая төгрөгийн 3 албан шаардлага өглөө.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна.

Бүлэг-А. Төсөл, арга хэмжээний ажлын даалгавар, техникийн тодорхойлолтыг холбогдох норм, дүрмийн дагуу боловсруулсан боловч төсөвт өртөг, санхүүжих дүнг бодитой тооцож төлөвлөөгүй байна

А.1 2023 онд шинээр хэрэгжихээр батлагдсан 7 төсөл, арга хэмжээний ажлын даалгавар, техникийн тодорхойлолт, зураг төсвийг хууль тогтоомж, норм, дүрэм журмын дагуу боловсруулсан байна

А.2 Аймгийн ИТХ-ын тогтоолд өмнөх оноос шилжих хөрөнгө оруулалтын ажлын төсөвт өртгийг дутуу баталсан. Халуун усны барилгын төсөвт өртгийн тооцооллыг үндэслэлтэй тооцож, эрх бүхий байгууллагаар батлуулаагүй байна.

А.3. Төсөл арга хэмжээний санхүүжилтийг гүйцэтгэлд үндэслэн олгосон байна.

Бүлэг-Б. Аймгийн ИТХ-аар батлагдсан төсөл, арга хэмжээг төлөвлөсөн хугацаанд нь хэрэгжүүлж ажиллахгүй байгаа нь хөрөнгө оруулалтын ажлын үр ашгийг бууруулж байна.

Б.1 Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгасан 7 төсөл, арга хэмжээнд хугацаанд нь гүйцэтгүүлж хүлээн аваагүй, 1 ажлыг техникийн шаардлага, ажлын тоо хэмжээний дагуу хэрэгжүүлээгүй байна.

Б.2. Захиалагч 2 төсөл, арга хэмжээнд зураг төсөв зохиогчоор хяналт тавиулаагүй, улсын комисс ажлын тоо хэмжээ дутуу, үүрэг даалгаврыг бүрэн хэрэгжүүлээгүй 1 ажлыг хүлээн авсан байна.

Б.3. Ашиглалтад хүлээн авсан 89.9 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг ашиглагч байгууллага данс бүртгэлд тусгаагүй байна.

В. Тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн боловч хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт 50 хувьтай төлөвлөсөн үр дүнд хүрээгүй байна.

В.1. Ашиглалтад хүлээн авсан 25.7 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг зориулалтын дагуу ашиглаагүй, хөрөнгө оруулалтын үр өгөөжийг бууруулж байна.

В.2. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ нь тэргүүлэх ач холбогдол, хэрэгцээ шаардлагыг хангасан ч төлөвлөсөн үр дүндээ хүрээгүй байна

ЗӨВЛӨМЖ

Аймгийн Засаг даргад:

1. Он дамжин хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг сайжруулж, аймгийн ИТХ-аар батлагдсан хугацаанд ашиглалтад оруулахад анхаарч ажиллах, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3-т заасны дагуу өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах гэж заасныг хэрэгжүүлэх

Аймгийн Засаг даргын Тамгын газарт:

1. Төсөл, арга хэмжээний төсөвт өртөг, санхүүжих дүнг АИТХ-аар үнэн зөв батлуулах, Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.7, 29.8 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан худалдан авах ажиллагааны тэгш боломжтой, ил тод, үр ашигтай байх зарчмыг баримтлан төсөвт өртөгт өөрчлөлт оруулах бол шинээр сонгон шалгаруулалт зарлах, бусад тохиолдолд гүйцэтгэгч байгууллагад давуу эрх олгохгүй байх, гэрээний хугацаанд ажлаа гүйцэтгээгүй 7 төсөл, арга хэмжээний гэрээг дүгнэхдээ алданги тооцох (*хавсралт №4-өөс дэлгэрэнгүйг үзнэ үү.*)

ШАЛГАГДАГЧ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ

Аудитын тайлангийн төсөлд санал ирүүлээгүй тул Дарга, Тэргүүлэх аудиторын тушаалаар тайланг баталгаажуулав.



ШАЛГАГДАГЧ БАЙГУУЛЛАГЫН САНАЛД ӨГСӨН ТАЙЛБАР

Төсөл, арга хэмжээний санхүүжилт олгосон жагсаалт

№	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг	2023 онд санхүүжүүлэх дүн	Гэрээний дүн	Гүйцэтгэгчийн	2023 онд олгосон санхүүжилтийн дүн	Үүнээс ТАХ-ний барьцаа	Дараа онд шилжсэн ажлын санхүүжилтийг барьцаа дансанд байршуулсан.	Магадлашгүй ажлын зардал	Гэрээний хэмнэлт	Дараа онд шилжих	Ажлын бодит гүйцэтгэл		
					Нэр							Хувиар	Ажил эхэлснээс хойших гүйцэтгэл, мөнгөн дүн	Тайлант үеийн гүйцэтгэл, мөнгөн дүн
1	Сүмбэр сумын Найрамдал хотхонд шинээр баригдаж байгаа барилгуудын цахилгаан хангамжийн ажил	240.9	137.6	240.9	"ОСО констракшн" ХХК	-					122.6	84%	197.7	-
	Сүмбэр сумын Найрамдал хотхонд шинээр баригдаж байгаа барилгуудын цахилгаан хангамжийн ажил	94.4	-	94.4	"Содон эрчис ХХК"	15.0	-					0%	15.0	15.0
2	Дулааны станцын дулаан дамжуулах төвүүдийн мэдээлэл, холбооны шугамын ажлын зураг, төсөв боловсруулах ажил	5.0	5.0	5.0	"Баярмега сервис" ХХК	5.0						90%	5.0	5.0
3	Халуун усны барилгын ажил /Сүмбэр сум, 2 дугаар баг/	350.1	223.0	350.1	"Юу Би Жи" ХХК	223.0		37.4				90%	185.6	185.6
4	Төрийн байгууллагуудыг цахимжуулахад шаардлагатай тоног төхөөрөмж, сурагчийн ширээ, сандал худалдан авах	107.4	107.4	107.3	"Монтех дистрибьюшн" ХХК	107.3	5.4			0.04		100%	107.3	107.3

5	Шинэ суурьшлийн бүс үүсгэх зураг төсөв боловсруулах ажил	22.5	6.7	22.5	"Перфект солюшн энд инженеринг" ХХК	-			6.7	70%	15.8	-		
6	1-р багт дахин төлөвлөлт хэрэгжүүлэх байршилд ерөнхий төлөвлөгөөний зураг төсөв боловсруулах	18.4	9.2	18.4	"Жаргалант хийц" ХХК	-			9.2	50%	9.2	-		
7	Нийтийн эзэмшлийн байрнуудын цахилгааны шит монтаж засварын ажил	89.9	19.4	89.9	"Хайрхан бар" ХХК	18.6	4.5	0.8		100%	89.9	18.6		
8	Шивээговь сумын шинэ суурьшлын бүсэд худаг гаргуулах, ухаалаг систем суурилуулах ажил	89.1	89.1	87.0	"Такамаса" ХХК	86.3	4.4	0.8	2.1	100%	86.3	86.3		
9	Чойр хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг тодотгож, шинэчлэл хийх ажил	200.0	200.0	198.0	"Сонголт дизайн" ХХК	158.4		2.0	39.6	100%	158.4	158.4		
10	Сүмбэр сумын 1-р баг Худалдаачны гудамжны тохижилтын ажил	217.9	217.9	214.5	"Алтай Рөүд" ХХК	214.5	79.0	3.4		65%	135.5	135.5		
11	УС-ДУ ОНӨААТҮГазарт аваарын нөөц генератор худалдан авах ажил	50.0	50.0	47.1	"Эрчим сансар" ХХК	47.1	2.4	2.9		100%	47.1	47.1		
12	Стандарт хэмжилзүйн хэлтэст шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах ажил	50.0	50.0	49.8	"Мэйжүрмэнт" ХХК	50.0	50.0	0.2		100%	-	-		
13	Баянтал, Шивээговь сумдад нөөц генератор худалдан авах ажил	52.0	52.0	51.5	"Эрчим сансарг" ХХК	51.5	2.6	0.5		100%	51.5	51.5		
14	Орон нутгийн өмчит байгууллагуудын их засварын ажил	364.9	364.9	364.4	"Цагаан толгойн нуур" ХХК	364.4	111.4	0.5		100%	253.0	253.0		
		1,952.3	1,532.0	1,940.7		1,341.0	19.1	277.8	1.5	11.6	178.0	89%	1,357.2	1,063.2

Хавсралт №2

Дараа онд шилжсэн төсөл, арга хэмжээний жагсаалт								(төгрөгөөр)
№	Төсөл арга хэмжээ	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Гэрээний дүн	Олгосон санхүүжилт	Дансны үлдэгдэлд	Үүнээс: Барьцаа дансанд шилжүүлсэн	Гүйцэтгэгч
Шилжих хөрөнгө оруулалт -2022 оноос шилжсэн боловч 2023 онд бүрэн хэрэгжээгүй 2024 он руу шилжсэн.								
1	1-р багт дахин төлөвлөлт хэрэгжүүлэх байршилд ерөнхий төлөвлөгөөний зураг төсөв боловсруулах	18,376,757	9,188,379	18,376,757	-	9,188,379		"Жаргалант хийц" ХХК
2	Шинэ суурьшлын бүс үүсгэх зураг төсөв	22,500,500	6,666,000	22,500,500	-	6,666,000		"Перфект солюшн энд инженеринг" ХХК
3	Сүмбэр сумын Найрамдал хотхонд шинээр баригдаж байгаа барилгуудын цахилгаан хангамжийн ажил	240,861,201	137,591,828	240,861,201	-	122,591,828		"ОСО констракшн" ХХК
		94,391,970	-	94,391,970	15,000,000			"Содон проект ХХК" Содон эрчис ХХК
4	Халуун усны барилгын ажил /Сүмбэр сум, 2 дугаар баг/	350,085,067	223,000,000	350,085,067	312,687,791	37,397,276	37,397,276	"Юу Би Жи" ХХК
5	Дулааны станцын дулаан дамжуулах төвүүдийн мэдээлэл, холбооны шугамын ажлын зураг, төсөв боловсруулах ажил	5,000,000	5,000,000	5,000,000	5,000,000	-	-	"Баярмега сервис" ХХК
ДҮН		731,215,495	381,446,207	731,215,495	332,687,791	175,843,483	37,397,276	
Шинээр эхлэх хөрөнгө оруулалт-2023 онд ашиглалтад оруулахаар төлөвлөсөн боловч 2024 онд шилжсэн								
1	Чойр хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг тодотгож, шинэчлэл хийх ажил	198,000,000	198,000,000	198,000,000	99,000,000	39,600,000		"Сонголт дизайн" ХХК
2	Сүмбэр сумын 1-р баг Худалдаачны гудамжны тохижилтын ажил	214,475,278	214,475,278	214,477,528	135,508,998	78,968,529	78,968,529	"Алтай Рөүд" ХХК
ДҮН		412,475,278	412,475,278	412,477,528	234,508,998	118,568,529	78,968,529	
НИЙТ ДҮН		1,143,690,773	793,921,485	1,143,693,023	567,196,789	294,412,012	116,365,805	

Хавсралт №3

Тайлант хугацаанд хүлээн авсан төсөл, арга хэмжээний жагсаалт

(төгрөгөөр)

№	Төсөл арга хэмжээ	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Гэрээний дүн	Олгосон санхүүжилт	Гэрээний хэмнэлт	Гүйцэтгэгч
Шилжих хөрөнгө оруулалт -2022 оноос шилжиж 2023 онд ашиглалтад хүлээн авсан.							
1	Төрийн байгууллагуудыг цахимжуулахад шаардлагатай тоног төхөөрөмж, сурагчийн ширээ, сандал худалдан авах	107,350,000	107,350,000	107,309,400	107,309,400	40,600	"Монтех дистрибьюшн" ХХК
2	Нийтийн эзэмшлийн байрнуудын цахилгааны шит монтаж засварын ажил	89,875,495	89,875,495	89,875,495	89,875,495	-	"Хайрхан бар" ХХК
ДҮН		197,225,495	197,225,495	197,184,895	197,184,895	40,600	
Шинээр эхлэх хөрөнгө оруулалт-2023 онд ашиглалтад хүлээн авсан							
3	Шивээговь сумын шинэ суурьшлын бүсэд худаг гаргуулах, ухаалаг систем суурилуулах ажил	89,077,000	89,077,000	87,018,161	87,018,161	2,058,839	"Такамаса" ХХК
4	УС-ДУ ОНӨААТҮГ газарт аваарын нөөц генератор худалдан авах ажил	50,000,000	50,000,000	47,100,000	47,100,000	2,900,000	"Эрчим сансар" ХХК
5	Стандарт хэмжилзүйн хэлтэст шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах ажил	50,000,000	50,000,000	49,800,000	49,800,000	200,000	"Мэйжүрмэнт" ХХК
6	Баянтал, Шивээговь сумдад нөөц генератор худалдан авах ажил	52,000,000	52,000,000	51,500,000	51,500,000	-	"Эрчим сансар" ХХК
7	Орон нутгийн өмчит байгууллагуудын их засварын ажил	364,870,000	364,870,000	364,400,585	364,400,585	-	"Цагаан толгойн нуур" ХХК
ДҮН		605,947,000	605,947,000	599,818,746	599,818,746	5,158,839	
НИЙТ ДҮН		803,172,495	803,172,495	797,003,641	797,003,641	5,199,439	

Хавсралт №4

Гэрээний хугацаа дууссан, сунгалт хийгээгүй алданги тооцох төсөл, арга хэмжээний жагсаалт

(сая төгрөгөөр)

№	Төсөл, арга хэмжээний нэр	Гүйцэтгэгчтэй гэрээ байгуулсан огноо	Гэрээний дүн	ХАА-нд мөрдөгдсөн журам	Гүйцэтгэгчийн	
					Нэр	Регистрийн дугаар
1	Сүмбэр сумын Найрамдал хотхонд шинээр баригдаж байгаа барилгуудын цахилгаан хангамжийн ажил	2022.06.13 2023-08-25	240.9	НТШ	"ОСО констракшн" ХХК	4612248
	Сүмбэр сумын Найрамдал хотхонд шинээр баригдаж байгаа барилгуудын цахилгаан хангамжийн ажил	2022-12-01 2023-12-31	94.4	ХА	"Содон эрчис ХХК"	5538491
2	Дулааны станцын дулаан дамжуулах төвүүдийн мэдээлэл, холбооны шугамын ажлын зураг, төсөв боловсруулах ажил	2022-12-23 2023-03-25 2023-05-10	5.0	ШГ	"Баярмега сервис" ХХК	5542308
3	Халуун усны барилгын ажил /Сүмбэр сум, 2 дугаар баг/	2022.07.18- 2022.09.16- 2022.12.15- 2023.07.01- 2023.12.01	350.1	НТШ	"Юу Би Жи" ХХК	5201209
4	Шинэ суурьшлын бүс үүсгэх зураг төсөв боловсруулах ажил	2022-07-18	22.5	ЗҮ	"Перфект солюшн энд инженеринг" ХХК	6090192
5	1-р багт дахин төлөвлөлт хэрэгжүүлэх байршилд ерөнхий төлөвлөгөөний зураг төсөв боловсруулах	2021.02.22- 2021.11.23	18.4	ШГ	"Жаргалант хийц" ХХК	5472105
6	Чойр хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг тодотгож, шинэчлэл хийх ажил	2023.08.04 2024.02.29	198.0	НТШ	"Сонголт дизайн" ХХК	6251501
7	Сүмбэр сумын 1-р баг Худалдаачны гудамжны тохижилтын ажил	2023.08.09 2023.09.22 2023.12.01	214.5	НТШ	"Алтай Рөүд" ХХК	5564077
Нийт			1,143.7			